

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын огноо: 2025 оны 9 сарын 10-ны өдөр

Хурлын байршил: Цахимаар (Ард Апп)

Хурал эхэлсэн цаг: 14 цаг 00 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Н.Хосбаяр

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 17,176,234 ширхэг буюу 68.7 хувь

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэх тухай;
2. Дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
3. Бусад;

Тэмдэглэл:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Эрсдэл, хөрөнгийн удирдлагын газрын захирал Г. Баярбат: Эрхэм хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр буюу 2025 оны 9 сарын 10-ны өдөр Ард Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэсний дагуу хурал эхлүүлж байна. Хурлыг нээж өгнө үү хэмээн Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Хосбаяр танийг урьж байна.

ХЭХ-н дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Хосбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр Ард Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал эхэлхэд бэлэн болсон байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Хосбаяр миний бие, ердийн гишүүн Г.Цогбадрах, Гүйцэтгэх захирал Н.Эрдэнэтүлга, Үйл ажиллагаа санхүү эрхэлсэн захирал Т.Батцэнгэл, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Эрсдэл, хөрөнгийн удирдлагын газрын захирал Г.Баярбат болон тооллогын комиссын гишүүд болох Ө.Бямбагэрэл, Ч.Даваацэрэн, А.Эрхбилгүүн нар оролцож байна. Хурлын дэг ёсоор тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл танийг хурлын ирцийг танилцуулж өгнө үү хэмээн урьж байна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Сайн байцгаана уу? Юуны өмнө хуралдаа идэвхтэй оролцож буй эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн Ард Даатгал ХК-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн 2025 оны 7 сарын 29-ний өдрийн 14/25 тоот тогтоолын дагуу зарласан байгаа, тус тогтоолд Компанийн тухай хуулийн 67-р зүйлд заасанчлан Тооллогын Комиссын эрх үүргийг хэрэгжүүлэхээр тооллогын комиссын даргаар Ө.Бямбагэрэл миний бие, гишүүдээр Ч.Даваацэрэн, А.Эрхбилгүүн нарыг тус тус томилосон. Хурлын дэгийн ирцийг баталгаажуулалтыг та

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ARD ДААТГАЛ



ТУЗ-ийн дарга
О. Одбаяр



ТУЗ-ийн гишүүн
Б. Золбоо



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Н. Хосбаяр



ТУЗ-ийн гишүүн
Г. Уянга



ТУЗ-ийн гишүүн
Г. Цогбадрах



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Б. Болорчимэг



ТУЗ-ийн гишүүн
Н. Эрдэнэтулга



ТУЗ-ийн гишүүн
С. Оргил



ТУЗ-ийн хараат бус гишүүн
Г. Хонгорзул

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ARD ДААТГАЛ

5

Ээлжит
Ээлжит бус

1

Эчнээ

6

Хуралдсан тоо

15

Шийдвэрлэсэн
асуудлын тоо

ТУЗ-өөр шийдвэрлэсэн онцлох шийдвэрүүд:

- ✓ Ногдол ашиг хуваарилах эсэх тухай
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- ✓ 2024 оны аудитлагдсан тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлт гарган батлах тухай
- ✓ Гүйцэтгэх захирлын үнэлгээ батлах тухай
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

ARD БААТГАЛ

№	Хувьцаа эзэмшигчид	12/31/2024		08/18/2025		Өөрчлөлт
		Тоо	%	Тоо	%	
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК *	14,216,586	56.87%	15,774,979	63.10%	1,558,393
2	С. Оргил	1,164,822	4.66%	1,164,822	4.66%	-
3	Н. Мөнхнасан	1,125,742	4.50%	-	0.00%	(1,125,742)
4	Г. Бат-Эрдэнэ	1,111,141	4.44%	1,042,221	4.17%	(68,920)
5	Бодь Даатгал	857,135	3.43%	857,135	3.43%	-
6	Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	3.28%	820,750	3.28%	-
7	БиДиСек ҮЦК	450,094	1.80%	279,462	1.12%	(170,632)
8	А. Сүхдорж	203,994	0.82%	203,994	0.82%	-
9	Ч. Амарбаатар	166,000	0.66%	166,000	0.66%	-
10	Бусад	4,883,736	19.53%	4,690,637	18.76%	(193,099)
	НИЙТ	25,000,000	100.00%	25,000,000	100.00%	-
Хувьцаа эзэмшигчдийн тоо		9,506		9,342		-164

*Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хамаарал бүхий компаниуд

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ НЭМЭГДҮҮЛЭХ

ARD БААТГАЛ

Одоогийн байгаа бүтэц

№	Нэр	Тоо ширхэг	Эзлэх хувь	Нэгж үнэ	Нийт дүн
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК *	15,774,979	62.73%	200	3,154,995,800
2	С. Оргил	1,164,822	4.66%	200	232,964,400
3	Г. Бат-Эрдэнэ	1,042,221	4.37%	200	208,444,200
4	Бодь Даатгал	857,135	3.43%	200	171,427,000
5	Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	3.28%	200	164,150,000
6	БиДиСек ҮЦК	279,462	1.16%	200	55,892,400
7	Бусад	5,060,631	20.37%	200	1,012,126,200
	НИЙТ ДҮН	25,000,000	100%		5,000,000,000

Нэмэгдүүлсний дараах бүтэц

№	Нэр	Тоо ширхэг	Эзлэх хувь	Нэгж үнэ	Нийт дүн
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК *	15,774,979	62.73%	600	9,464,987,400
2	С. Оргил	1,164,822	4.66%	600	698,893,200
3	Г. Бат-Эрдэнэ	1,042,221	4.37%	600	625,332,600
4	Бодь Даатгал	857,135	3.43%	600	514,281,000
5	Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	3.28%	600	492,450,000
6	БиДиСек ҮЦК	279,462	1.16%	600	167,677,200
7	Бусад	5,060,631	20.37%	600	3,036,378,600
	НИЙТ ДҮН	25,000,000	100%		15,000,000,000

Одоогийн байдлаар компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 200 (хоёр зуун) төгрөгөөр үнэлэгдэж нийт 25 (хорин таван) сая ширхэг хувьцаа буюу нийт 5 (таван) тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр компанийн дүрэм, тайлан балансд тусгагдсан байдаг. Бид энд ямар өөрчлөлт оруулж ирж байгаа гэхээр компанийн нэрлэсэн үнийг нэмэгдүүлж 600 (зургаан) төгрөг болгон нэмэгдүүлэх буюу дүрмийн санг нийт 15 (арван таван) тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх гэсэн санал оруулж ирж байна. Бид дүрмийн санг

АрдАпп-р шууд хүргэгдэж байгаа бөгөөд АрдАпп-р нэвтрэн орж Ард Даатгал ХК-ийн ээлжит бус хурлын баннер байршсан байгаа бөгөөд үүгээр нэвтрэн орж асуулт, хариулт цэсээр дарснаар хүссэн асуултаа асуух боломжтой, мөн сошиал сувгаар комментоор асуулт асуух боломжтой. Хурал зохион байгуулах комиссоос бүх асуултуудыг нэгтгэн бид бүхэн асуултуудад хариулаад явна.

ХЭХ-н дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Хосбаяр: За тэгвэл Хурал зохион байгуулах комиссоос АрдАпп болон компанийн сошиал сувгаар ирсэн асуултууд байвал нэгтгэн танилцуулж өгөхийг хүсье.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Эрсдэл, хөрөнгийн удирдлагын газрын захирал Г. Баярбат: За одоогоор асуулт хариулт ирээгүй байгаа бөгөөд энэ хугацааг ашиглаад компанийн Гүйцэтгэх захирал Н.Эрдэнэтулга танийг хуралтай холбоотой үг хэлнэ үү хэмээн урьж байна.

Гүйцэтгэх захирал Н.Эрдэнэтулга: За сайн байцгаана уу, хуралдаа оролцож байгаа эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хувьд өнөөдрийн хурлын шийдвэр маш их үнэ цэнэтэй гэж хувь хүнийхээ хувьд дүгнэж байна. Хувьцаа эзэмшигчдийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх нь хувьцаа эзэмшигчдэд ямар үр ашигтай вэ гэсэн зүй ёсны асуулт байгаа гэдэгт итгэлтэй байна. Энд оршил болгоод хэлэхэд Санхүүгийн зохицуулах хорооноос 2012 онд Даатгалын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 5 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх шийдвэр гарч хойшлуулж байгаад 2018 онд эцэслэн хэрэгжиж дууссан түүхтэй байдаг. Тэгэхээр 2012 оны тухайн үеийн эдийн засаг, зах зээлийн байдал, 2025 оны эдийн засаг, зах зээлийн байдал бол тэс өөр байгааг маш их зөрүүтэй байгаа болно. Энэ оршилтой холбогдуулаад хэлэхэд хувьцаа эзэмшигчиддээ дөрвөн зүйлийг заавал дурьдах нь зүй ёсных гэж бодож байна.

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх нь эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ. Компанийг урт хугацаандаа тогтвортой ашигтай ажиллах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, одоо хэрэгжээд буй том төслүүдэд оролцох
2. Ногдол ашиг болгон тараалгүйгээр компанийн хөрөнгийг нэмэгдүүлэн үнэ цэнийг нэмэгдүүлснээр компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
3. Хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх
4. Санхүү зохицуулах хороо буюу Зохицуулагч байгууллагын шаардлагын асуудал өнөөдөр зүй ёсоор тавигдаад дүрмийн сан нэмэгдүүлэх эхний хэлэлцүүлэг саяхан болж өнгөрсөн үүнтэй холбоотой, аливаа зүйл бидний тооцоолсон бус цаг хугацааны давхцаад өнөөдрийн хурлаар гарсан шийдвэр Хувьцаа эзэмшигчид болон компанийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх шийдвэр гаргахаар боллоо.

Компанийн хувьд энэ жил хоёр чухал үйл ажиллагааг сайжруулахаар хэрэгжүүлээд явж байна. Нэгдүгээрт нь компанийн үйл ажиллагаа сайжруулах, өндөр зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулах, дотоод үйл ажиллагаа процессийг сайжруулах,

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар: Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 9 сарын 10-ны өдрийн 14:00 цагт Цахимаар (АрдАпп)

Бүртгэлийн өдөр: 2025 оны 8 сарын 18-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа: 2025 оны 9 сарын 8-ны өдрийн 15:00 цаг хүртэл

Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл

Тооллогын комиссын гишүүд: Ч. Даваацэрэн, А.Эрхбилгүүн

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал болон хурлын үеэр өгсөн саналыг тус тус тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 17,176,234 ширхэг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсон ба үүнээс:
 - 1.1. Зөвшөөрсөн: 17,174,803 ширхэг буюу 99.9%
 - 1.2. Татгалзсан: байхгүй
 - 1.3. Түдгэлзсэн: байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцсэн асуудал хоёр:

“АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №3

2025 оны 9 сарын 10-ны өдөр

Санал хураалтын дүнгийн талаар

Компанийн нэр: Ард Даатгал ХК

Компанийн хаяг: Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот

Хурлын төрөл: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар: Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 9 сарын 10-ны өдрийн 14:00 цагт Цахимаар (АрдАпп)

Бүртгэлийн өдөр: 2025 оны 8 сарын 18-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа: 2025 оны 9 сарын 8-ны өдрийн 15:00 цаг хүртэл

Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл

Тооллогын комиссын гишүүд: Ч. Даваацэрэн, А.Эрхбилгүүн

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал болон хурлын үеэр өгсөн саналыг тус тус тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.5-д “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот” гэж заасныг “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар, 1710 тоот” гэж өөрчлөх;
 - 1.2. Компанийн дүрмийн 4.1-д “Компани нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна” гэж заасныг “Компани нь 600 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна” гэж өөрчлөх;
2. Энэхүү шийдвэрийн 1 дахь хэсэгт заасан нэмэлт өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг, хурал зохион байгуулах комисс, тооллогын комисст талархлаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДАРГА



Н.ХОСБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.БАЯРБАТ